

## Бүтээгч яагаад бүх амь бодийг аврахыг хүсдэг вэ

Бүтээгч яагаад бүх амь бодийг аврахыг хүсдэг вэ? Учир нь тэр бүх амь бодиудад нигүүлсэнгүй ханддаг! Учир нь Тэр бүх амь бодиудад амь өгсөн.

Сансарын биетийн Үүсэл, Тогтворжилт, Доройтол, Устлын мөчлөгийн эцсийн шатанд Бүтээгч Гурамсан ертөнцийг бүтээхэд болон бүх амь бодийг аврах олон арга зам, боломжуудыг зохицуулахад 200 сая жил зарцуулсан. Үүний зэрэгцээ хүн төрөлхтний соёл, сэтгэлгээ, зан үйлийн үндэс суурийг тавьсан. Тэрээр мөн бүх амь бодийн нүгэлт үйлийн үрийг хөнгөлөх, арилгахад өөрийн бурханлаг биеийг ашигласан! Тэр бүх амь бодийн авралын төлөө бүхнээ зориулсан.

Төгсгөлийн цаг болж авралыг эхлүүлэх үед хүн төрөлхтнийг Бурхдын тавьсан шаардлагад нийцүүлэхийн тулд өнгөрсөн 200 сая жилийн турш Бүтээгч дэлхийд нэгэн зэрэг олон хувилгаан дүрээр тоо томшгүй удаа төрж хүн төрөлхтний соёлын эх үндсийг тавьсан, хүн төрөлхтний ёс суртахууныг сахин хамгаалж ирсэн. Түүхийн арав, арван сая жилийн урт удаан хугацааны хүлээлтэд амь бодиудын ахин дахин төрөх эргэлт давтагдсаар, улмаар дэлхийн ихэнх хүмүүсийн жинхэнэ сүнслэг биес нь (бүх үндэстэн угсаатныг багтаан) Бүтээгчтэй ямар нэгэн ураг төрлийн холбоотой болсон нь Бүтээгчийг дэлхийн хүмүүсийг, Өөрийн хүмүүсийг илүү их хайрлахад хүргэсэн. Төгсгөлийн цаг ирэхэд авралыг амжилттай явуулахын тулд Бүтээгчтэй ийм холбоогүй хүмүүс энэ үед хүн болж төрөх боломжгүй. Энэ цаг үед Дэлхийн хүмүүсийн жинхэнэ биес нь Түүний хүмүүс юм. Хүмүүсийн шүтдэг Бурхад ч, Фа ба Дао түгээхэд үйлчлэхээр хүн болж төрцгөөсөн, тэд мөн Түүний хүмүүс. Зорилго нь, Бүтээгчийн хүмүүнийг аврах замыг засахын тулд хүний биеийг ашиглан бурханлаг соёлын суурийг тавих явдал байсан юм. Мөн Бүтээгчийн эцсийн аврал иртэл хүлээх явцад хүн төрөлхтний ёс суртахууныг сахин хамгаалж байхын тулд янз бүрийн ариун шашныг үлдээсэн юм. Бүтээгч хүн ардаа хайрлах эрхтэй, мөн өөрийн хайрлавал зохих хүмүүсээ илүү их хайрладаг. Энэ бол түүний эрх, хэн ч хөндлөнгөөс оролцох эрхгүй! Энэ бол Түүний амь бодид үзүүлэх дээд нигүүлсэл!

Бүтээгч бол Сансар огторгуйн бүх Бурхдын Эзэн, Тэр бүх Эздийн Эздийг, бүх Хаадын Хаадыг бүтээгч, Тэр бүх амь бодиудын Эзэн, Гурамсан ертөнцийн хүмүүс, Бурханлаг оршихуйнууд болон материаллаг зүйлсийг багтаан бүхнийг Тэр бүтээсэн. Түүний хайр бол бүх амь бодид зориулагдсан цаглашгүй дээд адислал! Түүний ивээлийг хүртэхээс илүү аз завшаан гэж энэ дэлхийн хүмүүст үгүй!

Багш Ли Хонжи

2023 оны дөрөвдүгээр сарын 17